

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЙМГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ,
ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ТӨА-2025/49-ШТА-ГА

Зуунмод 2025 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Саранчимэг

Утас: 70273465 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272248 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Аудитор Б.Нямсүрэн

Утас: 70272582 Цахим хаяг: nyamsurenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Хүснэгтийн товъёг	2
Графикын товъёг	2
Зургийн товъёг	2
Товчилсон үгийн тайлбар	3
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	4
Аудитын зорилго	4
Аудитын хамарсан хүрээ, хугацаа	4
Аудитын хязгаарлалт	4
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	4
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	5
Үндсэн мэдээлэл	5
Хүндрэл бэрхшээл	5

БҮЛЭГ 1. Аймгийн хөгжлийн санд 2017-2024 онуудад нийт 6,439.5 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, зээлийн эргэн төлөлтөөр 3,868.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.6

А.1 Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хуулиудтай уялдаагүй, тухайн үед мөрдөгдөж байсан Засгийн газрын тогтоолоор баталсан сум хөгжүүлэх сангийн журамтай зарим заалт нь давхардсан байна.6

А.2. Аймгийн хөгжлийн сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 3,736.3 сая төгрөгийн эх үүсвэр нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан үйлдвэр, үйлчилгээний чиглэлийн төслийг санхүүжүүлэх боломжийг алдагдуулж байна.7

БҮЛЭГ 2. Аймгийн хөгжлийн сангаас олгож буй зарим зээл нь журмын шаардлагыг хангахгүйгээр олгогдсон, үр дүнгүй ашиглагдсан, зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.10

Б.1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан үйлдвэрлэлийн болон төслийн тэргүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөрийг сонгон шалгаруулсан ч Аймгийн хөгжлийн сангийн журам зөрчигдсөн байна.10

Б.2. Аймгийн хөгжлийн сангаас аймгийн Засг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан үйлдвэрлэлийн болон төслийн тэргүүлэх чиглэлийг дэмжин зээл олгосон байна. ...13

Б.3. Аймгийн хөгжлийн сангаас олгож буй зарим зээлүүд нь журмын шаардлагыг хангахгүйгээр олгогдсон, үр дүнгүй ашиглагдсан, мөн зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.....15

Б.4. Аймгийн хөгжлийн сангийн зөвлөлийн тогтоолоор үйл ажиллагааны зардал батлагдсан боловч 14.6 сая төгрөгөөр хэтэрүүлэн зарцуулсан байна.16

БҮЛЭГ 3. Аймгийн хөгжлийн сангийн зөвлөлөөс хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байгаа нь сангийн үндсэн чиглэл зорилго алдагдахад хүрсэн байна.....18

В.1. Аймгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлагнал, зээлийн хяналтын тогтолцоонд дотоод хяналт сул, журмын хэрэгжилт хангалтгүй, санхүүгийн сахилга бат алдагдсан байдалтай байна.18

В.2. Аймгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд Төрийн аудитын газар болон Санхүү, хяналт, дотоод аудитын газраас өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.19

ДҮГНЭЛТ:.....21

ЗӨВЛӨМЖ:22

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:.....23

Хүснэгтийн товьёг

Хүснэгт№ 1 Аймгийн хөгжлийн сангийн эх үүсвэр 2017-2024

Хүснэгт№ 2 Аймгийн хөгжлийн сангийн зээл, хүүгийн авлага, хугацаа хэтрэлт, өмнөх онтой харьцуулсан байдал 2017-2024

Хүснэгт№ 3 Дэмжигдэж олгохоор шийдвэрлэсэн төсөл

Хүснэгт№ 4 Аймгийн хөгжлийн сангаас олгосон зээлийн төрөл

Хүснэгт№ 5 Аймгийн хөгжлийн сангийн санхүүгийн байдлын тайлан

Графикын товьёг

График № 1 Аймгийн хөгжлийн сангийн орлого

График № 2 Аймгийн хөгжлийн сангийн зээл, зээлий хүүгийн авлага

График № 3 Санал асуулгын дүн

График № 4 Санал асуулгын дүн

Зургийн товьёг

Зураг № 1 Эрдэнэ суманд "Баялаг фийд ХХК" Тэжээлийн үйлдвэр

Зураг № 2 Борнуур суманд "Арангат Баянхангай" хоршоо

Зураг № 3 Баянчандмань суманд "Илт оргил" хоршоо

Зураг № 4 Батсүмбэр сум "Нарны сааль сүү" хоршоо

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АХС	Аймгийн хөгжлийн сан
ДЭХГ	Дулааны эрчим хүчний газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СХДАГ	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын сэдэв батлах тухай” 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/107, 108 дугаар тушаал, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасныг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилго

Аймгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх, хөрөнгийг зарцуулах, үйл ажиллагааг холбогдох журам, хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хяналтыг хэрэгжүүлэн үр дүнг тооцсон эсэхэд аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулж аудитын дүнг Аймгийн Засаг дарга, ИТХ-д танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдсэн. Дээрх зорилгын хүрээнд дараах дэд зорилтын дагуу аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Аймгийн хөгжлийн санг хууль, журмын дагуу төлөвлөж, бүрдүүлсэн үү?
- Аймгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан байна уу?
- Аймгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй байна уу?

Аудитын хамарсан хүрээ, хугацаа

Аудитад “Аймгийн хөгжлийн сан”-д аймгийн шилжих үлдэгдлээс 2017-2024 онд нийт 5,100.0 сая төгрөгийн санхүүжилт эх үүсвэрийг олгосон байна. 2024 оны жилийн эцсийн зээлийн авлагын үлдэгдэл болох 259 зээлдэгчийн 6,201.9 сая төгрөгийн 26 суманд олгосон зээлийн ашиглалт үр дүнг хамрууллаа. 2017 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааны сангийн үйл ажиллагааг хамруулж, тухайн байгууллага, албан тушаалтны холбогдох шийдвэр, хувийн хэрэг, баримт материалыг түүвэрлэн шалгасан.

Аудитын хязгаарлалт

Шүүхийн шийдвэртэй, хууль хяналтын байгууллагад шалгагдаж буй асуудлыг аудитад хамруулахгүй бөгөөд тухайн сантай холбоотойгоор хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаа асуудал байхгүй байна.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС-100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ыг баримтлан аудитад хамрагдсан байгууллагуудаас авсан мэдээлэл, зээлийн хувийн хэрэг, зээлийн мэдээллийн тооцоолол болон цуглуулсан нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, лавлагаа, тайлбар авах, дүн шинжилгээ, түүвэрлэлт хийх зэрэг арга зүйг ашиглаж аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгаа, тайланг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд

- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль
- Сангийн сайд, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2022 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн А122/А-172 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан “Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам”
- Аймгийн ИТХ-ын 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 4 дүгээр хуралдааны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн хөгжлийн сангийн журам"
- Хөгжлийн түүчээ-Төв аймаг 2024 аймгийн хөгжлийн зорилт
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
- Холбогдох бусад хууль тогтоомж эрх зүйн актууд.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал удирдаж, аудитын менежер О.Амаржаргал чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Саранчимэг, аудитор Д.Бямбасүрэн, Б.Нямсүрэн нар гүйцэтгэв.

Аудитын урьдчилсан судалгааны үе шатны ажлыг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс, төлөвлөлтийн үе шатны ажлыг 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс тус тус эхлэн аудитын төлөвлөгөөг 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр батлуулж, талбарын үе шатны ажлыг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн гүйцэтгэж, тайлагналын үе шатны ажлыг 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрөөс 2025 оны 7 дугаар сарын 21-нд дуусган, аудитын тайланг 2025 оны 07 дугаар сарын 24-ний өдөр дарга, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан аймгийн ИТХ, Засаг дарга-д хүргүүллээ.

Үндсэн мэдээлэл

Аймаг хөгжүүлэх сан 2009 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 6 дугаар хуралдааны 05 дугаар тогтоолоор “Аймгийн хөгжлийн сан байгуулах тухай” шийдвэрээр сангийн журмыг баталсан байна. Энэхүү Сангийн журмын зорилго нь аймгийн хөгжил дэвшилд иргэд, олон нийт, ААН байгууллагуудын оруулах хувь нэмэрийг нэмэгдүүлэх, оролцоог өргөжүүлэх, орон нутгийн хөгжлийн төлөө гэсэн тэдний идэвх санаачлагыг өрнүүлэхэд оршино гэж тодорхойлсон байна.

АХС-ийн журмыг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны 03 дугаар сарын 30-ний өдрийн 15 дугаар хуралдааны 8 дугаар тогтоолоор журмын 3.2 болон 4.5 дахь заалтыг өөрчилсөн байна. Энэ нь зээлийг сарын 1,0 хувийн хүүтэй байсныг жилийн 2,4 хувийн хүүтэй болгож хүүг бууруулсан, хугацааг 5 хүртэлх жил болгон өөрчилсөн, “онцгой ач холбогдол өгөх хөгжлийн төслүүдэд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж хэлэлцүүлэн дэмжүүлж, хүүгүй зээл олгож болно” гэсэн өөрчлөлт тус тус хийгдсэн байна.

Аймгийн хөгжлийн санд аймгийн шилжих үлдэгдлээс 2017 онд 600.0 сая төгрөг, 2018 онд 600.0 сая төгрөг, 2019 онд 600.0 сая төгрөг, 2020 онд 600.0 сая төгрөг, 2021 онд 1,000.0 сая төгрөг, 2022 онд 1,000.0 сая төгрөг, 2023 онд 1,500.0 сая төгрөг, 2024 онд 1,000.0 сая төгрөг, нийт 6,900.0 сая төгрөгийг олгохоор ИТХ-ын тогтоолоор шийдвэрлэснээс дээрх жилүүдэд нийт 5,100.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Хүндрэл бэрхшээл

Байхгүй.

БҮЛЭГ 1. Аймгийн хөгжлийн санд 2017-2024 онуудад нийт 6,439.5 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, зээлийн эргэн төлөлтөөр 3,868.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

А.1 Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хуулиудтай уялдаагүй, тухайн үед мөрдөгдөж байсан Засгийн газрын тогтоолоор баталсан сум хөгжүүлэх сангийн журамтай зарим заалт нь давхардсан байна.

“Аймгийн хөгжлийн сангийн журам”-ыг шинэчлэн Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 4 дүгээр хуралдааны 06 дугаар тогтоолоор баталсан байна. Энэхүү тогтоолын 2.1-д хөрөнгийн эх үүсвэрийг дараах байдлаар бүрдүүлнэ гэж заасан байна. Үүнд:

1. Аймгийн төсвөөс ажлын байр нэмэгдүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зориулалтаар хуваарилсан хөрөнгө
2. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас олгосон хандив
3. Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөр, гадаадын иргэд, аж ахуйн нэгж, уламжлалт харилцаат гадаад орон, сумаас олгосон буцалтгүй тусламж, хандив
4. Сангаас хөрөнгийг арилжааны банканд байршуулсны хүү, төлбөр
5. Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр

“Аймгийн хөгжлийн сангийн журам”-ын 2.1-д “Аймгийн төсвөөс ажлын байр нэмэгдүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зориулалтаар хуваарилсан хөрөнгө” гэж заасан байна. Энэ нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн эх үүсвэр нь иргэн, ажил олгогч, түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэгч болон уг үйл ажиллагаанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байна”, 22 дугаар зүйлийн 22.1.2-т “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын эх үүсвэр нь орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө байна” гэж заасан нь журмын зориулалт нь хуулийн заалттай агуулгын хувьд ижил төстэй, давхардсан зохицуулалттай байхаар тусгагдсан нь эрх зүйн зохицуулалтын уялдаа, ялгаа, давхцалыг тодорхой болгох шаардлагатайг харуулж байна.

Төсвийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан 24¹ дүгээр зүйлд Засгийн газраас зээл олгох нөхцөлийг тодорхойлсон. Тухайлбал, 24¹.1-д “Тухайн жилийн төсвийн хуулиар эх үүсвэр нь батлагдсан тохиолдолд улсын төсвөөс дараах зорилгоор зээл олгож болно” гэж, харин 24¹.1.2-т “Засгийн газрын тусгай сангаас хуульд заасан зориулалтаар зээл олгоно” гэж тус тус заасан. Гэтэл “Аймгийн хөгжлийн сангийн журам”-ын 2.1-д “Аймгийн төсвөөс ажлын байр нэмэгдүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зориулалтаар хуваарилсан хөрөнгөөр эх үүсвэр бүрдүүлнэ” гэж заасан нь дээрх хуулийн заалттай нийцэхгүй байна.

Аймгийн хөгжлийн сангийн журмын 3 дугаар зүйлийн 3.1.б-д “мал аж ахуйг байгалийн гамшигт аюул, цас зудаас хамгаалах, аймгийн хэмжээний өвс, тэжээлийн нөөц бэлтгэх зорилгоор иргэн, аж ахуйн нэгжүүдийг дэмжихэд эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр зээл олгох”-оор тусгасан байна. Мөн журмын 4 дүгээр зүйлийн 4.6.б-д “төсөл хэрэгжүүлэгч нь хуулийн этгээд байх бөгөөд тухайн сум, аймагт бүртгэлтэй, аймагт татвар төлдөг, аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг, цаашид тогтвортой ажиллах, аймаг орон нутгаас ажиллах хүчний нөөцөө бүрдүүлдэг байх” гэсэн шаардлагатай зөрчилдөж байна. Энэ нь 3.1.б-д хувь хүн зээлд хамрагдах боломжтой боловч 4.6.б-д хуулийн этгээдийг төсөл хэрэгжүүлэгчээр хүлээн зөвшөөрсөн гэх журам доторх зохицуулалт хоорондоо нийцэхгүй байна.

2017 онд батлагдсан Аймгийн хөгжлийн сангийн журам нь тухайн үед хүчин төгөлдөр байсан хууль, заалтуудыг үндэслэн батлагдсан боловч 2020 онд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэгдэж, журамд үндэслэсэн 18.1.3 (в) заалт хүчингүй болсон байна. Мөн шинэчилсэн хуулийн 19.1-д орон нутгийн чиг үүргийг өөрөөр тодорхойлсон нь уг журмын зарим заалттай нийцэхгүй байдал үүсгэж байна. Үүнээс гадна, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 4.1-д “Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагааг ашгийн төлөө хэлбэрээр байгуулагдсан хуулийн этгээд эрхэлнэ” гэж заасан нь төрийн байгууллага болох Аймгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаатай зөрчилдөж байгаа тул журмыг хууль тогтоомжийн өөрчлөлтүүдтэй уялдуулан шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

А.2. Аймгийн хөгжлийн сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 3,736.3 сая төгрөгийн эх үүсвэр нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан үйлдвэр, үйлчилгээний чиглэлийн төслийг санхүүжүүлэх боломжийг алдагдуулж байна.

Аудитад хамрагдаж буй 2017-2024 онуудад “Аймгийн хөгжлийн сангийн журам”-ын 2.1-д заасны дагуу дараах эх үүсвэрийг бүрдүүлж ажилласан байна.

Аймгийн ИТХ-ын жил бүрийн төсөв батлах тухай тогтоолд аймгийн шилжих үлдэгдлээс ажлын байр нэмэгдүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зориулалтаар хуваарилсан хөрөнгө 2017-2024 онд нийт 6,900.0 сая төгрөгийн эх үүсвэр олгохоор төлөвлөж батлагдсанаас гүйцэтгэлээр 5,000.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Иргэд, ААН байгууллагад олгосон зээлийн хүүгийн орлого, алданги 2017 онд 66.4 сая төгрөг, 2018 онд 71.2 сая төгрөг, 2019 онд 76.7 сая төгрөг, 2020 онд 98.3 сая төгрөг, 2021 онд 131.6 сая төгрөг, 2022 онд 168.2 сая төгрөг, 2023 онд 211.3 сая төгрөг, 2024 онд 223.6 сая төгрөг, нийт 1,047.4 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр тооцсон байна.

Сангаас хөрөнгийг арилжааны банканд байршуулсны хүү, төлбөрийн орлогоор 2017 онд 3.7 сая төгрөг, 2018 онд 5.4 сая төгрөг, 2019 онд 7.2 сая төгрөг, 2020 онд 11.8 сая төгрөг, 2024 онд 1.1 сая төгрөг, нийт 29.2 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Тус санд Төв аймгийн Засаг даргын 2021 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 01/586 дугаар албан бичгээр Хас банканд байршуулсан байсан мөнгөнөөс банктai хамтран ажиллах гэрээний дагуу хөнгөлөлттэй зээлийг зохион байгуулах, хяналт тавих, сургалт зөвлөгөөн өгөх, зардлыг тооцон нийт дүнгээр 190.4 сая төгрөгийг төвлөрүүлж эх үүсвэр болгосон байна. Энэхүү эх үүсвэр нь Хас банкны Зуунмод салбар болон Төв аймгийн ЗДТГ-ын хооронд байгуулагдсан 2009 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 12/09-1 дугаартай Хамтран ажиллах гэрээ, 2015 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр байгуулагдсан 01 дугаартай хамтран ажиллах гэрээгээр харилцан тохиролцож жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийг аймаг, орон нутагт хэрэгжүүлэх зорилгоор “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн сан” дансанд байршуулсан 179.0 сая төгрөг нь өссөн дүнгээр 190.4 сая төгрөг болсон байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн №А/135 дугаар захирамжаар Тө.Засаг дарга 100140051000 тоот данснаас Зээлийн батлан даалтын санд 100.0 сая төгрөг шилжүүлсэн байна. Энэ нь 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Аймгийн хөгжлийн сангийн дансанд Зээлийн батлан даалтын сангаас Төв аймгийн хөрөнгө оруулалтын гэрээний дүн буцаав гэсэн гүйлгээний утгатай 100.0 сая төгрөгийг буцаан шилжүүлснийг эх үүсвэр болгосон байна.

Орон нутгийн төсвөөс “Шинэ хөдөө” төслийн хүрээнд санхүүжүүлсэн 425.0 сая төгрөгийг “Монтбелиард үнээний гэрээ” нэртэй итгэлийн зээлийг 2022 оны 11-р сард олгосныг Аймгийн хөгжлийн санд төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн байна. Энэхүү зээл нь

хүүгүй, 5 жилийн хугацаатай бөгөөд Аймгийн хөгжлийн санд эргэн төлөлтийг төвлөрүүлэх нөхцөлтэйгээр гэрээ байгуулсан. Зээлийн эргэн төлөлтөөр 2022 онд 36.25 сая төгрөг, 2023 онд 6.25 сая төгрөг, 2024 онд 30.0 сая төгрөг, нийт 72.5 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

“Аймгийн хөгжлийн сан”-д 2017-2024 онуудад нийт 6,439.5 сая төгрөгийн эх үүсвэр бүрдсэн байна.

Аймгийн хөгжлийн сангийн эх үүсвэр 2017-2024

Хүснэгт №1

/сая.төг/

Эх үүсвэр	Аймгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө		Зээлийн хүүгийн орлого, алданги	Арилжааны банканд байршуулсны хүү, төлбөр	Бусад гэрээгээр		Бусад /ЖДҮДОН С, БДЗС/	Нийт эх үүсвэр	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2017 он	600.0	600.0	66.4	3.7	-	-	-	600.0	670.1
2018 он	600.0	600.0	71.2	5.4	-	-	-	600.0	676.6
2019 он	600.0	600.0	76.7	7.1	-	-	-	600.0	683.9
2020 он	600.0	500.0	98.3	11.8	-	-	-	600.0	610.1
2021 он	1,000.0	1,000.0	131.6	-	-	-	190.4	1,000.0	1,322.0
2022 он	1,000.0	1,000.0	168.2	-	425.0	36.3	-	1,425.0	1,204.5
2023 он	1,500.0	-	211.3	-	-	6.3	100.0	1,500.0	317.6
2024 он	1,000.0	700.0	223.6	1.1	-	30.0	-	1,000.0	954.7
Нийт	6,900.0	5,000.0	1,047.4	29.2	425.0	72.5	290.4	7,325.0	6,439.4

Эх сурвалж: Аймгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлан, анхан шатны баримт

Аймгийн хөгжлийн сан 2017-2024 онд шилжих үлдэгдлээс олгосон санхүүжилт 5,000.0 сая төгрөг, бусад сангаас 362.9 сая төгрөг, зээл болон хүүгийн эргэн төлөлт 3,868.3 сая төгрөг, банкны хүүгийн орлого 29.2 сая төгрөг, харилцах дансны нийт орлого 9,260.4 сая төгрөг төвлөрүүлсэн байна. 2017 оны эхэнд төрийн сангийн харилцах дансанд 9.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан байна.

График №1

/ сая.төг/



Аймгийн хөгжлийн сангаас олгосон зээлийн эргэн төлөлтөөс орох эх үүсвэрийг жил бүр төлөвлөж, баталж ажиллаагүйгээс шалтгаалан зээлийн эргэн төлөлт хангалтгүй, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл жилээс жилд нэмэгдсээр байна. Доорх хүснэгтээс харахад хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн хэмжээ 7.9 сая төгрөгөөс 1,227.4 сая төгрөг хүртэл өссөн бөгөөд нийт 3,736.3 сая төгрөгийн буюу нийт авлагын 60,2 хувийн эх үүсвэр дахин эргэлтэд орж чадаагүй, авлагын үлдэгдэлтэй байна.

Аймгийн хөгжлийн сангийн зээл, хүүгийн авлага, хугацаа хэтрэлт, өмнөх онтой харьцуулсан байдал 2017-2024

Хүснэгт №2

/сая.төг/

Хугацаа	АХС-ийн авлага		Авлагын өсөлт, бууралт		АХС-ийн хугацаа хэтэрсэн зээл		Хугацаа хэтэрсэн зээлийн өсөлт, бууралт	
	Зээлдэгчийн тоо	Зээл, хүү, алдангийн үлдэгдэл	Зээлдэгчийн тоо	Зээл, хүү, алдангийн үлдэгдэл	Зээлдэгчийн тоо	Зээл, хүү, алдангийн үлдэгдэл	Зээлдэгчийн тоо	Зээл, хүү, алдангийн үлдэгдэл
2016	13	322.1			8	133.5		
2017	27	1,000.3	14	678.2	13	327.7	5	194.2
2018	46	1,653.4	19	653.1	13	335.5	0	7.9
2019	71	2,234.6	25	581.3	11	298.1	-2	(37.4)
2020	88	2,782.7	17	548.1	21	575.5	10	277.4
2021	170	3,849.5	82	1,066.8	37	1,098.9	16	523.4
2022	232	4,532.1	62	682.7	54	1,600.4	17	501.5
2023	243	5,371.7	11	839.6	135	2,508.8	81	908.5
2024	293	6,201.9	50	830.2	197	3,736.3	62	1,227.4

Эх сурвалж: Аймгийн хөгжлийн сангийн зээлийн гэрээ, эргэн төлөлтийн судалгаа

Энэ нь сангийн хөрөнгийн үр ашигтай байдал, санхүүгийн сахилга бат, хяналтын тогтолцоонд анхаарах шаардлагатай бөгөөд зээлийн эргэн төлөлтийн төлөвлөлт, хяналтыг сайжруулах, хариуцлагын механизмыг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байна

График №2

/сая.төг/



БҮЛЭГ 2. Аймгийн хөгжлийн сангаас олгож буй зарим зээл нь журмын шаардлагыг хангахгүйгээр олгогдсон, үр дүнгүй ашиглагдсан, зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.

Б.1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан үйлдвэрлэлийн болон төслийн тэргүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөрийг сонгон шалгаруулсан ч Аймгийн хөгжлийн сангийн журам зөрчигдсөн байна.

Аймгийн хөгжлийн сангийн журмыг 2017 онд шинэчлэн боловсруулж, аймгийн ИТХ-ын 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 06 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж, аймгийн хөгжлийн сангийн зөвлөл нь 11 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Зөвлөлийн бүрэлдэхүүн нь албан тушаалаар томилогддог ба тухайн жилүүдэд журмын дагуу солигдон ажилласан байна.

Аймгийн хөгжлийн сангийн зөвлөлийн хурлын тогтоолоор 2018 онд 4 үйл ажиллагааны чиглэлээр 15 төсөл, 2019 онд 2 үйл ажиллагааны чиглэлээр 12 төсөл, 2020 онд 5 үйл ажиллагааны чиглэлээр 17 төсөл, 2021 онд 6 үйл ажиллагааны чиглэлээр 13 төсөл, 2022 онд 6 үйл ажиллагааны чиглэлээр 29 төсөл, 2023 онд 6 үйл ажиллагааны чиглэлээр 14 төсөл, 2024 онд 8 үйл ажиллагааны чиглэлээр 15 төсөл хэрэгжүүлэх тэргүүлэх чиглэлийн төлөвлөгөө тус тус баталж, 2017 онд тэргүүлэх чиглэлийн төлөвлөгөө батлаагүй байна.

Аймгийн хөгжлийн сангийн Зөвлөлөөс 2017–2024 онуудад 305 төсөлд 8,398.6 сая төгрөгийн санхүүжилт, АХС-ийн журмын сангийн хөрөнгийн зориулалтад тусгагдаагүй зээлжих батламжаар 19 иргэнд 190.0 сая төгрөг, итгэлийн зээлээр 600.0 сая төгрөгийг олгохоор тогтоол гарган нийт 9,188.6 сая төгрөгийг зарцуулахаар шийдвэрлэсэн байна. Үүнд:

- 2017 онд 7 удаагийн шийдвэрээр 6 чиглэлээр 13 төсөлд 630.0 сая төгрөг
- 2018 онд 4 удаагийн шийдвэрээр 4 чиглэлээр 21 төсөлд 668.0 сая төгрөг
- 2019 онд 3 удаагийн шийдвэрээр 5 чиглэлээр 27 төсөлд 880.6 сая төгрөг
- 2020 онд 5 удаагийн шийдвэрээр 7 чиглэлээр 24 төсөлд 1,076.0 сая төгрөг, нэмэлтээр зээлжих батламжаар 50.0 сая төгрөг
- 2021 онд 7 удаагийн шийдвэрээр 7 чиглэлээр 98 төсөлд 1,169.0.0 сая төгрөг, итгэлийн зээл 190.0 сая төгрөг
- 2022 онд 7 чиглэлээр 106 төсөлд 1,013.0 сая төгрөг, итгэлийн зээл 315.0 сая төгрөг
- 2023 онд 4 удаагийн шийдвэрээр 7 чиглэлээр 39 төсөлд 1,530.0 сая төгрөг, зээлжих батламжаар 60.0 сая төгрөг, итгэлийн зээлээр 95.0 сая төгрөг
- 2024 онд 5 чиглэлээр 47 төсөлд 1,432.0 сая төгрөг, зээлжих батламжаар 80.0 сая төгрөг

Дэмжигдэж олгохоор шийдвэрлэсэн төсөл

Хүснэгт №3 /сая төг/

он	Зээлжих батламж, итгэлийн зээл, Ковид эх		Аймгийн хөгжлийн сангийн хурлаар дэмжигдсэн төсөл														Шийдвэрлэсэн дүн	
			Хүнсний үйлдвэрлэл		Барилга материал үйлдвэрлэх		ЖДҮ болон хөнгөн үйлдвэрлэл		Мал аж ахуй		Хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж		Газар тариалан		Үйлчилгээ			
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	Нийт дүн
2017			3	102.4	1	98.2	-	-	3	210.9	2	88.5	3	110.0	1	20.0	13	630.0
2018			-				4	39.0	5	82.2	7	409.8	4	87.0	1	50.0	21	668.0
2019			11	255.0	-	-	7	305.6	4	110.0	-	-	4	110.0	1	100.0	27	880.6
2020	5	50.0	6	175.0	1	80.0	4	88.0	6	348.0	1	100.0	4	195.0	2	90.0	29	1,126.0
2021	10	283.0	7	340.0	-	-	4	70.0	26	288.0	4	98.0	43	190.0	4	90.0	98	1,359.0
2022	2	315.0	6	134.0	2	80.0	1	20.0	17	409.0	1	30.0	10	215.0	2	125.0	41	1,328.0
2023	9	155.0	6	320.0	1	60.0	2	80.0	7	260.0	6	180.0	13	485.0	3	145.0	47	1,685.0
2024	8	80.0	5	330.0	-	-	-	-	4	130.0	8	282.0	26	520.0	4	170.0	55	1,512.0
Дүн	34	883.0	44	1,656.4	5	318.2	22	602.6	72	1,838.1	29	1,188.3	107	1,912.0	18	790.0	331	9,188.6

Эх сурвалж: АХС-ийн Зөвлөлийн тогтоол

Аймгийн хөгжлийн сангийн журмын 4.3-т “Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулах үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөх, шинээр бий болгох талаар хийсэн төслүүдийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс хүлээн авч дүгнэлт гарган Сангийн Зөвлөлд хүргүүлнэ” гэж заасан байхад 2017-2024 онуудад аж ахуй нэгж байгууллага, иргэдээс ирүүлсэн төслүүдийг судлан гаргасан дүгнэлт байхгүй, шууд Сангийн Зөвлөлд танилцуулж тогтоол гарган шийдвэрлэсэн байна. Жишээ нь 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор “Бөбүн трейд” ХХК-д 100.0 сая төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэсэн боловч тус компани нь Монгол банкны мэдээллийн санд муу зээлдэгчийн төлөвт бүртгэгдсэн, мөн зээлийн шалгуур шаардлагыг хангаагүй байсан тул зээл олгогдоогүй байна. Энэ нь сонгон шалгаруулалтын үйл явц хангалтгүй, эрсдэлийг урьдчилан тогтоох байдал сул байсантай холбоотой байна.

Аймгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэх төслүүдэд тэргүүлэх чиглэлийг баримталж зээл олгож байгаа ч төслийн сонгон шалгаруулалт, эргэн төлөлтийн чанарын үнэлгээ дутмаг хангалтгүй, мэдээллийн ил тод байдал болон хяналтын тогтолцоо сул, эрсдэлийг тооцох талаар журамд заагаагүйгээс 197 төслийн 3,736.3 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл үүсэхэд нөлөөлсөн байна.

АХС-ийн Зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 5 дугаар тогтоолоор Ти Эн Жи Пи ХХК-д 80.0 сая төгрөг, иргэн Ш.Т-т 80.0 сая төгрөг, Өндөр овоот хангай ХХК-д 50.0 сая төгрөг, Зоргол Хайрханы хишиг ХХК-д 20.0 сая төгрөгийг Аймгийн хөгжлийн сангийн журмын 4.5-д “Аймгийн хөгжлийн сангаас олгох зээл нь жилийн 4 хувийн хүүтэй, 3 хүртэлх жилийн хугацаатай, нэг зээлдэгчид олгох зээлийн дээд хэмжээ 100 хүртэл сая төгрөг байна” гэж заасныг зөрчин 42 сараар олгож, зээлийн хүү алданги нэмэгдэж Ти Эн Жи Пи ХХК 92.8 сая төгрөг, иргэн Ш.Т 78.4 сая төгрөг, Зоргол Хайрханы хишиг ХХК 11.4 сая төгрөгийн тус тус хугацаа хэтэрсэн үлдэгдэлтэй эргэн төлөгдөөгүй байна.

АХС-ийн Зөвлөлийн 2021 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 02 дугаар тогтоолоор улаан буудайн үрийн зориулалтаар 150.0 сая төгрөг, сонгинын үрийн зориулалтаар 40.0 сая төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэснээс Хөдөө аж ахуйн дэмжих сангийн 100900019032 тоот дансанд 150.0 сая төгрөг, Астила-Увс ХХК-ийн 5015094736 тоот дансанд 40.0 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн байна. Гэтэл 16 ААН байгууллагад 150.0 сая төгрөгийн улаан буудайн үр, 22 иргэнд 40.0 сая төгрөгийн сонгинын үрийг итгэлийн зээл хэлбэрээр Аймгийн хөгжлийн сангийн журмын 4.6.г заалтыг зөрчиж, барьцаа хөрөнгөгүйгээр гэрээ байгуулан олгогдсоноос 19 зээлдэгчийн нийт хүү алданги нэмэгдэж 84.7 сая төгрөг хугацаандаа төлөгдөөгүй байна.

АХС-ийн Зөвлөлийн 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 2022/02 дугаар тогтоолоор “Төв-Эрдэнэс” ОНӨААТҮГ-д ногоон байгууламжийг нөхөн сэргээх зориулалтаар 80.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Гэвч тус байгууллага 2017 онд байгуулагдсанаас хойш тухайн санхүүжилт олгогдох үе хүртэл үйл ажиллагаа явуулаагүй байсан бөгөөд зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй, зориулалт бусаар зарцуулж үүний улмаас зээлийн хүү, алданги нэмэгдэж, нийт 88.9 сая төгрөгийн эргэн төлөгдөөгүй хугацаа хэтэрсэн үлдэгдэлтэй байна.

АХС-ийн Зөвлөлийн 2022 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 2022/04 дугаар тогтоолоор 4 иргэн, 1 хоршоонд төмсний болон луувангийн комбайн худалдан авсан үнэнд 135.0 сая төгрөг, Төв Чандмань ДЭХГ-т уурын зуухны тогоо худалдан авахад 30.0 сая төгрөг, мөн 2023 онд иргэн Ц.Т-д төмсний комбайн худалдан авахад 35.0 сая төгрөгийн итгэлийн зээл хэлбэрээр тус тус олгосон. Гэвч олгосон зээлд хүү, алданги нэмэгдэж, 5 иргэний нийт 170.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн, эргэн төлөгдөөгүй зээлийн үлдэгдэлтэй байна. Мөн иргэн Б.Г нь төмсний комбайнаа ашиглахгүйгээр худалдан борлуулж гэрээний үүргээ зөрчсөн байна.

АХС-ийн Зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 2022/01 дугаар тогтоолоор “Төмсний үр шинэчлэл” төслийн хүрээнд 41 иргэнд нийт 150.0 сая төгрөгийн санхүүжилтийг итгэлийн зээлийн хэлбэрээр олгосон нь Аймгийн хөгжлийн сангийн журамд заагдаагүй нөхцөлөөр шийдвэрлэж, тухайн зээлд барьцаа хөрөнгө тавигдаагүй, санхүүгийн эрсдэлийг хангалттай үнэлээгүй нь зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтрэхэд нөлөөлсөн байна.

АХС-ийн Зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 02 дугаар тогтоолоор 120.0 сая төгрөгийн санхүүжилттэйгээр хэрэгжихээр шийдвэрлэсэн “Сонгинын үрийн шинэчлэл” төсөл нь сонгон шалгаруулалтын үйл явц хангалтгүй байснаас гадна, тухайн төслийн хүрээнд итгэлийн зээлийн гэрээгээр олгогдсон 60.0 сая төгрөг нь Аймгийн хөгжлийн сангийн журамд заагдаагүй нөхцөлөөр олгогдсон, зээлд тавигдах барьцаа хөрөнгийн шалгуур, шаардлага хангалтгүй, зээлийн эргэн төлөлт хугацаа хэтэрсэн, зээлийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах нөхцөл бий болоход нөлөөлсөн байна.

Аймгийн хөгжлийн сангийн журмын 4.6.б-т зааснаар төсөл хэрэгжүүлэгч нь тухайн сум, аймагт бүртгэлтэй, татвар төлөгч, орон нутагт тогтвортой үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд байх зохицуулалтыг зөрчин 2024 онд “Агро-тех Жаргалант” ХХК-д тоног төхөөрөмжийн төсөлд зориулан 50.0 сая төгрөгийн зээл олгосон байна.

Аймгийн хөгжлийн сангийн журмын 4.6.б-т заасны дагуу төсөл хэрэгжүүлэгч нь тухайн сум, аймагт бүртгэлтэй, татвар төлөгч, орон нутагт тогтвортой үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд байх, мөн энэ журмын 4.8-д тусгаснаар зээлээр хэрэгжиж буй төслийн ажил нь батлагдсан төсөв, норм, хугацаанд нийцэж байгаа эсэхэд тухайн объект байрлаж буй сумын Засаг дарга хяналт тавьж, ажлын явц, эргэн төлөлтийн нөхцөл байдлын талаар Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст мэдээлэл хүргүүлж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж байх талаар тусгагдсан ч хэрэгжээгүй байна.

Сонгон шалгаруулсан төслүүдийн хэрэгжилтийн талаар сум, орон нутгийн удирдлага мэдээлэлгүй, аж ахуй нэгж, иргэн нь төслөө танилцуулдаггүй нь зээл зориулалт бусаар зарцуулагдах, хугацаа хэтрэх, хэрэгжихгүй байх эрсдэлийг үүсгэсэн байна.

Иргэдээс авсан Санал асуулгын дүнгээс харахад оршин суугаа нутагт Аймгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний талаарх иргэдийн мэдлэг, мэдээлэл хангалтгүй байна. Тодруулбал: Таны оршин суугаа нутагт энэ сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээ байдаг уу гэсэн асуултад 41 хүн буюу олонх нь “мэдэхгүй” гэж хариулсан бол, зөвхөн 14 хүн “байдаг” гэж хариулсан байна.

Санал асуулгын дүнгээс харахад Аймгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, төсөл сонгон шалгаруулалт нь иргэдийн дунд ил тод, шударга явагдаж байгаа эсэх талаар эргэлзээтэй байдал давамгайлж байна. Үүнд: Та сангийн хөрөнгө зарцуулалт, төсөл сонгон шалгаруулалт ил тод, шударга явагдаж байна гэж үздэг үү гэсэн асуултад 25 хүн буюу хамгийн олонх нь “мэдэхгүй” гэж хариулсан нь мэдээллийн хүртээмж, ил тод байдал хангалтгүй байгааг илтгэж байна. Мөн 20 хүн “үгүй” гэж хариулсан нь шударга бус байдалд итгэлгүй байгааг харуулж байна. Зөвхөн 9 хүн “тийм” гэж хариулсан нь итгэлцэл сул байгааг илэрхийлж байна.

График №3




График №4



Энэ нь тухайн сангийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй төслүүдийн талаарх мэдээлэл түгээх, ил тод байдал, олон нийтэд хүргэх ажил хангалтгүй байгааг илтгэж байна. Иймд: Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, Төсөл, арга хэмжээний үр дүнг ил тод тайлагнах, Сум, багийн түвшинд мэдээлэл түгээх сувгуудыг сайжруулах шаардлагатай байна.

Зээлийн хяналт, үнэлгээ сул байсан, зээл олгохдоо эрсдэлийн үнэлгээ хангалтгүй хийсэн, барьцаа хөрөнгийн баталгаа хангалтгүй, удирдлагын хариуцлага сул, зарим тохиолдолд улс төрийн нөлөөтэй, ашиг сонирхлын зөрчилтэй зээл олгогдсон, эдийн засгийн нөхцөл байдал нөлөөлсөн тухайлбал цар тахлын нөхцөл байдал нь гадаад дотоод хүчин зүйлс зээлдэгчдийн төлбөрийн чадварт нөлөөлсөн байна.

Б.2. Аймгийн хөгжлийн сангаас аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан үйлдвэрлэлийн болон төслийн тэргүүлэх чиглэлийг дэмжин зээл олгосон байна.

Аймгийн хөгжлийн санд 2017-2024 онуудад 3,076.6 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдсэнээс 2019 онд 2 зээлдэгчийн 37.4 сая төгрөгийн, 2020 онд 4 зээлдэгчийн 141.7 сая төгрөгийн, 2021 онд 4 зээлдэгчийн 17.9 сая төгрөгийн, 2022 онд 23 зээлдэгчийн 117.8 сая төгрөгийн, 2023 онд 30 зээлдэгчийн 311.5 сая төгрөгийн, 2024 онд 34 зээлдэгчийн 454.9 сая төгрөгийн нийт 97 зээлдэгчийн 1,080.7 сая төгрөгийн зээл, зээлийн хүү, алдангийн үлдэгдэл бүрэн хаагдсан байна.

Аймгийн хөгжлийн сангаас аймгийн эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх, дотоодын нийт бүтээгдэхүүнд боловсруулах үйлдвэр цех байгуулахыг бодлогоор дэмжин ажилласнаар Эрдэнэ сумын Агрико Эрдэнэ ХХК сүү цагаан идээний үйлдвэр, Баялаг фийд ХХК тэжээлийн үйлдвэр, Алтанбулаг сумын Лигийн ухаа ХХК бяслагийн үйлдвэр өргөтгөл, Кей өү эм эм жи эл ХХК мах боловсруулах, ногоо савлах үйлдвэр, Заамар сумын Содон нар трейд ХХК ажлын гутлын үйлдвэр, Зуунмод сумын Кэй эйч ти өү ХХК жимс жимсгэнэ боловсруулах, цэлцгэнүүр чихрийн үйлдвэр, Акадоо мандал ХХК бууз баншны үйлдвэр, Аксион трейд ХХК мэдрэлийн эмнэлэг, Баянчандмань сумын Баянбараат оргил ХХК талхны үйлдвэр, Залуучуудын хөгжил төв, үйлчилгээний төв, Эрхэст бугуйл ХХК 400 тн багтаамж бүхий зоорины аж ахуй, Баяндэлгэр сумын Нүүдэлчин Агро ХХК кластер үнээний ах ахуй, Жаргалант сумын Голден арвай ХХК гурил, тэжээл, гоймонгийн үйлдвэр зэрэг төслүүдийг тус тус 1,050.0 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн байна.

Зүраг №2



Зургаг №3



Аймгийн хөгжлийн сангаас Ковид-19 цар тахлын нөхцөлд ард, иргэдээ халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эдийн засгаа сэргээх цаг үед үйл ажиллагаа нь доголдсон, түр саатсан жижиг дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй

иргэдийн бизнес эрхлэлтийг дэмжсэн чиглэсэн эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэхээр Борнуур, Дэлгэрхаан, Зуунмод, Эрдэнэ, Өндөрширээт, Эрдэнэсант сумын 19 иргэнд 130.0 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх чиглэлээр зээл олгосон байна.

Б.3. Аймгийн хөгжлийн сангаас олгож буй зарим зээлүүд нь журмын шаардлагыг хангахгүйгээр олгогдсон, үр дүнгүй ашиглагдсан, мөн зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.

Аймгийн хөгжлийн сангийн зээлийн зориулалт нь “Хөгжлийн түүчээ-Төв аймаг 2024” аймгийн хөгжлийн хэтийн зорилт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон салбарын тухайлсан бодлого, хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлж, аймгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулах боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлийн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх мөн мал аж ахуйг байгалийн гамшигт аюул, цас зудаас хамгаалах аймгийн хэмжээний өвс, тэжээлийн нөөц бэлтгэх иргэн, аж ахуйн нэгжүүдийг дэмжихэд эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр зээл олгож зарцуулах журамтай.

Аудитын хамрагдах хугацаа болох 2017-2024 онуудад хөдөө аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр нийт 361 иргэн, аж ахуй нэгж, хоршоодод 8,848.6 сая төгрөгийн зээл олгосон байна. Үүнд:

- ХАА, мах махан бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүний зориулалтаар 1,804.4 сая төгрөг,
- Үхрийн аж ахуй, сүүний чиглэлээр 542.4 сая төгрөг,
- Газар тариалан, ногоон тэжээл, улаан буудай, төмсний үр, сонгинын үр, хүлэмж, зоорь, хүнсний ногооны чиглэлээр 2,585.5 сая төгрөг,
- Үйлдвэрлэл үйлчилгээ, тоног төхөөрөмж, цехийн чиглэлээр 3,775.3 сая төгрөг,
- 2018, 2023, 2024 онуудад Төв аймгийн үзэсгэлэн худалдаагаар шалгарч зээлжих эрхийн батламж авсан 10 иргэнтэй холбоотой 97.0 сая төгрөг, 2021 онд Ковид цар тахлын үед 5 иргэн, 1 аж ахуй нэгжид нийт 44.0 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зориулалтаар зээл тус тус олгосон байна.

АХС-аас олгосон зээлийн төрөл

Хүснэгт №4

/сая төг/

Зээл олгосон он	Мал, Махны аж ахуй	Сүүний аж ахуй	Хөдөө аж ахуй, газар тариалан	Үйлдвэрлэл, үйлчилгээ, тоног төхөөрөмж	Эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх /Ковид/	Зээлжих эрхийн батламж	Олгосон зээл
2017	85.9	167.4	180.0	186.7			620.0
2018	114.5		180.5	327.0		17.0	639.0
2019	50.0	70.0	50.0	550.6			720.6
2020	180.0	50.0	230.0	548.0			1,008.0
2021	463.0	130.0	350.0	341.0	44.0		1,328.0
2022	241.0	60.0	635.0	367.0			1,303.0
2023	480.0	40.0	453.0	705.0		30.0	1,708.0
2024	190.0	25.0	507.0	750.0		50.0	1,522.0
Нийт дүн	1,804.4	542.4	2,585.5	3,775.3	44.0	97.0	8,848.6

Эх сурвалж: АХС-ийн зээлийн гэрээ

Аймгийн хөгжлийн сангаас зээл авсан иргэн, аж ахуйн нэгж, хоршоодын зарим зээлийн гэрээг дахин сунгасан зөрчил байна. Тодруулбал: Нийт 3 иргэн, 7 ААН, 4 хоршоод нь хамрагдсан бөгөөд, зээлдэгчдийн нийт 680.0 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрснээс 52.6 сая төгрөгийн зээл, зээлийн хүү, алданги нь эргэн төлөгдөж 627.4 сая төгрөгийн зээлийн авлагын хугацааг сунгаж журам зөрчсөн байна.

Аудитад хамрагдаж буй онуудад сонгон шалгарсан төсөл хэрэгжүүлэгчийн 69,2 хувь буюу 167 аж ахуй нэгжид 6,120.8 сая төгрөг, үлдсэн 30,8 хувь нь буюу 194 иргэнд 2,727.8 сая төгрөгийн зээл олгосон байна. Энэ нь Аймгийн хөгжлийн сангийн журмын үйл ажиллагааны чиглэлийн 4.б-д “Төсөл хэрэгжүүлэгч нь хуулийн этгээд байх бөгөөд тухайн

сум, аймагт бүртгэлтэй, аймагт татвар төлдөг, аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг, цаашид тогтвортой ажиллах, аймаг, орон нутгаас ажиллах хүчний нөөцөө бүрдүүлдэг байх” гэсэн журмын заалттай нийцэхгүй байна.

Төв аймгийн Эрдэнэ сумаас сонгогдсон Эрдэнэ хүнс ХХК нь мах бэлтгэх зориулалтаар 2020 онд 100.0 сая төгрөгийн зээл авсан бөгөөд өмнөх зээлээс 2.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байхад 2023 онд дахин 100.0 сая төгрөгийн зээл олгосон ба зээлийн гэрээг дахин сунгасан байна. Энэ нь журмын 4.в дэх заалт Аймгийн тусгай сангуудаас өмнө авсан зээлээ зориулалтын дагуу үр дүнтэй ашигласан, хугацаанд нь эргүүлэн төлсөн байх шаардлагыг хангаагүй байна.

Төв эрдэнэс ОНӨААТҮГ нь 2022 онд ногоон байгууламж, нөхөн сэргээх зориулалтаар 80.0 сая төгрөгийн зээл авсан ба зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй, үйл ажиллагаа явуулаагүй зөвхөн удирдлагын зардалд зарцуулагдсан байна.

Мөн 2021-2024 онуудад ХХААГ-ын дарга, зээлдэгч нарын хооронд байгуулсан зээлийн гэрээ нь дараах зөрчилтэй байна. Үүнд: 2021.05.05-нд авсан 7.5 сая төгрөгийн улаан буудайн үр авсан иргэн М.Б нь тухай үеийн ХХААГ-ын дарга Н.Г-д 7.5 сая төгрөгийг төлсөн гэх боловч /бичгээр тайлбартай/ тус сангийн дансанд ороогүй байна.

АХС-ийн Зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор 2 ААН, 1 иргэнд 120.0 сая төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэснээс дараах 3-н иргэнтэй хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх зээлийн гэрээ байгуулан иргэн Ц.О-д 30.0 сая төгрөг, иргэн Д.Б-д 30.0 сая төгрөг, иргэн Б.О-д 60.0 сая төгрөгийг тус тус олгохоор гэрээ байгуулсан байна. Гэвч дээрх зээлийг иргэдийн дансанд шилжүүлэлгүй тус шийдвэрт тусгагдаагүй Үйзэнгийн овоо ХХК-тай худалдах, худалдан авах гэрээ байгуулан 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр “төл сонгинын үрийн зээл олгов” гэж 120.0 сая төгрөг шилжүүлсэн байна. Тус сангийн журамд шууд худалдан авах талаар ямар нэгэн зүйл, заалт тусгаагүй байхад худалдан авах ажиллагааны холбогдох хууль, журмыг зөрчин сонгон шалгаруулалтгүйгээр гэрээ байгуулан мөнгө шилжүүлсэн нь сангийн үйл ажиллагааны журмыг ноцтой зөрчсөн байна.

Аудитын явцад дээрх иргэдээс гэрээний хэрэгжилт, төслийн үр дүн, зээлийн эргэн төлөлтийн талаар тодруулахад иргэн Ц.О 30.0 сая төгрөгийн зээлийг өөр хүнд авч өгсөн, иргэн Д.Б нь 30.0 сая төгрөгийн зээл болон сонгинын үр аваагүй гэх ба аудитын хугацаанд 30.0 сая төгрөгийг сангийн дансанд буцаан төлсөн иргэн Б.О нь 60.0 сая төгрөгийн сонгинын үр тариалалт хийсэн гэх боловч өөрийн газаргүй тариалалт хийсэн нь нотлогдохгүй байна.

Б.4. Аймгийн хөгжлийн сангийн зөвлөлийн тогтоолоор үйл ажиллагааны зардал батлагдсан боловч 14.6 сая төгрөгөөр хэтэрүүлэн зарцуулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 4 дүгээр хуралдааны 06 дугаар тогтоолоор “Аймгийн хөгжлийн сангийн” журмыг баталсан байна. Уг журмын 3в-д сангийн хөрөнгийн зориулалтыг сангийн үйл ажиллагаатай холбоотой урсгал зардлыг санхүүжүүлэхэд сангийн хөрөнгийн хүүгийн орлогын 50 хүртэл хувийг зарцуулж болно гэж заасны дагуу аудитын хамрагдаж буй хугацаанд баримталж ажилласан байна.

Аймгийн хөгжлийн сангаас 2017-2024 онуудад цалин урамшуулалд 78.2 сая төгрөг, шатахуунд 3.4 сая төгрөг, дотоод албан томилолтын зардалд 10.3 сая төгрөг, шуудан холбооны зардалд 4.2 сая төгрөг, бичиг хэргийн зардалд 2.1 сая төгрөг, дансны хөтөлсний шимтгэл болон бусад зардалд 7.6 сая төгрөг нийт 105.8 сая төгрөг зарцуулсан байна.

Аймгийн хөгжлийн сангийн 2017-2024 оны үйл ажиллагааны зардлын төсвийг шалгахад 2020-2024 онуудад АХС-ийн Зөвлөлийн даргын тогтоолоор баталж өгсөн байна. 2020 онд АХС-ийн Зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолын

2 дугаар хавсралтаар 2020 оны үйл ажиллагааны зардлыг 7.3 сая төгрөгөөр баталж нягтлан бодогчийн урамшуулалд 4.8 сая төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 5.4 сая төгрөг зарцуулж, 0.6 сая төгрөг хэтрүүлэн зарцуулсан байна.

2022 онд АХС-ийн Зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 2022/01 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар 2022 оны үйл ажиллагааны зардлыг 22.7 сая төгрөгөөр баталж нягтлан бодогчийн цалин, урамшуулалд 11.5 сая төгрөг баталснаас гүйцэтгэлээр 16.5 сая төгрөг зарцуулж, 5.1 сая төгрөг хэтрүүлэн зарцуулсан байна. Мөн шуудан холбооны зардлыг 0.7 сая төгрөгөөр баталснаас 1.2 сая төгрөг зарцуулж, 0.5 сая төгрөг хэтрүүлэн зарцуулсан байна.

2023 онд АХС-ийн Зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар 2023 оны үйл ажиллагааны зардлыг 31.1 сая төгрөгөөр баталж нягтлан бодогчийн цалин, урамшуулалд 15.3 сая төгрөг баталснаас гүйцэтгэлээр 22.9 сая төгрөг зарцуулж, 7.6 сая төгрөг хэтрүүлэн зарцуулсан байна. Мөн шуудан холбооны зардлыг 0.7 сая төгрөг, бичиг хэргийн зардлыг 0.5 төгрөгөөр тус тус баталснаас шуудан холбооны зардалд 1.0 сая төгрөг, бичиг хэргийн зардалд 0.5 сая төгрөг зарцуулж, нийт 0.3 сая төгрөг хэтрүүлэн зарцуулсан байна.

2024 онд АХС-ийн Зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 01 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар 2024 оны үйл ажиллагааны зардлыг 39.4 сая төгрөгөөр баталсан байна. Томилолтын зардалд 5.4 сая төгрөг, шуудан холбооны зардалд 0.7 сая төгрөгөөр тус тус баталснаас гүйцэтгэлээр томилолтын зардалд 5.8 сая төгрөг, шуудан холбооны зардалд 0.8 сая төгрөг зарцуулж, нийт 0.5 сая төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан байна.

БҮЛЭГ 3. Аймгийн хөгжлийн сангийн зөвлөлөөс хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байгаа нь сангийн үндсэн чиглэл зорилго алдагдахад хүрсэн байна.

В.1. Аймгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлагнал, зээлийн хяналтын тогтолцоонд дотоод хяналт сул, журмын хэрэгжилт хангалтгүй, санхүүгийн сахилга бат алдагдсан байдалтай байна.

Аймгийн хөгжлийн сангийн 2024 оны мөнгөн хөрөнгө нь 317.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд энэ нь арилжааны банканд байршсан байна.

Мөн Аймгийн хөгжлийн сангийн зээлийн авлага 2017 оноос 6,7 дахин буюу 5,273.3 сая төгрөгөөр өссөн байна.

Аймгийн хөгжлийн сангийн санхүүгийн байдлын тайлан

Хүснэгт №5

/сая төг/

Балансын үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024
Төрийн сангийн харилцах данс	-	0.7	1.0	113.9	336.6	815.7	-	-
Арилжааны банкны харилцах данс	15.1	45.4	137.6	1.0	2.5	4.5	166.4	317.8
Зээлийн авлага	928.6	1,653.6	2,152.8	2,782.7	3,858.1	4,537.3	5,377.0	6,201.9
Байгууллагаас авах авлага	-	-	-	-	-	-	-	1.6
Бараа материал	-	0.0	-	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгө	-	-	-	-	3.6	5.4	4.9	4.1
Эргэлтийн хөрөнгийн дүн	943.7	1,699.8	2,291.4	2,897.6	4,200.7	5,362.9	5,548.3	6,525.3
Өмнөх оны үр дүн	329.5	943.7	1,611.2	2,291.4	2,897.6	4,200.7	5,362.9	5,548.3
Тайлант үр дүн	614.2	756.0	680.2	606.2	1,303.2	1,162.2	185.4	977.0
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	943.7	1,699.8	2,291.4	2,897.6	4,200.7	5,362.9	5,548.3	6,525.3

Аймгийн хөгжлийн сангийн зарцуулалттай холбоотой дараах зөрчил илэрсэн байна.

Үүнд:

1. Шинэ хөдөө төслийн хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүжигдсэн 425.0 сая төгрөгийн зээлийн авлагыг бүртгэж тайлагнаагүй зөрчилд 2025 онд СХДАГ-аас авлагыг бүртгэх албан шаардлага бичсэн байна.
2. Аймгийн хөгжлийн сангийн дансанд 2023 оны 1 дүгээр сарын 09-ний өдөр зээлийн батлан даалтын сангаас буцаалт гэж 100.0 сая төгрөг шилжиж орсныг Аймгийн Засаг дарга дансанд өглөгөөр тайлагнаагүй байна.
3. Аймгийн хөгжлийн сангийн данснаас 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Н.Ц-ийн 5721246609 тоот дансанд бууз банш цех зээл олгов гэж 30.0 сая төгрөгийн зээл олгосон байна. Гэтэл энэхүү зээлийг олгосон талаар Зөвлөлийн шийдвэргүй, санхүүгийн баримтад төлбөрийн хүсэлт, зээлийн гэрээ, хөрөнгийн барьцаа зэрэг анхан шатны баримтгүйгээр зээл олгосон мөн зээлийн авлагын бүртгэлд зээл, зээлийн хүүг авлагаар тайлагнаагүй зөрчил илэрлээ.
4. Улаан буудайн үр, монгбелиярд үүлдрийн үнээ, төл сонгино, төмсний үрийн нийлүүлэх төслүүдийн зээлийн гэрээг тухайн үеийн ХХААГ-ын даргатай байгуулсан байна. Энэ нь 2021-2024 онд нийт 86 зээлдэгчийн 885.0 сая төгрөгийн зээлээс 204.0 сая төгрөгийн зээлийг эргэн төлж, 681.0 сая төгрөгийн зээлийг төлүүлээгүйгээс 386.5 сая төгрөг буюу нийт зээлийн 56,8 хувь нь хугацаа хэтэрсэн байна.
5. АХС-ийн Зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 2022/01 дугаартай тогтоолын 4 дүгээр хавсралтад заасан "төмсний үрийн шинэчлэх" дэмжигдсэн төслийн жагсаалтад ороогүй 5 иргэнд 29.5 сая төгрөгийн зээлийг олгосон байна. Мөн төмс нийлүүлсэн Агьт хүнс ХХК-ийн 25.6 сая төгрөгийн өр

барагдуулаагүй байгаа бөгөөд энэ нь маргаантай тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй үлдэгдэлтэй байна.

6. АХС -ийн Зөвлөлийн 2022 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 2022/04 дугаартай тогтоолын “лууван болон төмсний комбайн” төслийн 130.0 сая төгрөгийн зээлийн гэрээнд эргэн төлөлтийн хуваарь хийгдээгүй, анхан шатны баримт бичгийн зөрчилтэй байна.
7. Мөн зээлийн гэрээний дагуу зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлдэгчийн тооцоог хийхдээ өдрөөр тооцоогүйгээс хүү алдангийг 67.9 сая төгрөгөөр зөрүүтэй дутуу тооцсон байна.

В.2. Аймгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд Төрийн аудитын газар болон Санхүү, хяналт, дотоод аудитын газраас өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Төсвийн тухай хуульд заасан цаглаврын дагуу Төв аймаг дахь Төрийн аудитын газар жил бүр Аймгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайланд аудит хийж, түүвэрт хамруулан алдаа, зөрчлийг илрүүлж, таслан зогсоох албан шаардлага хүргүүлж мөн сангийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр зөвлөмж өгч ажилласан. Гэвч аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байсаар байгаа нь жил бүр давтагдсан алдаа, зөрчлөөс харагдаж байна. Энэ нь зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хариуцлагын тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

Аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын газраас 2019-2024 оны үйл ажиллагаанд хяналт хийж Аймгийн хөгжлийн сангийн зээлийн хүүг зөв тооцох, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг шүүхээр шийдвэр гаргуулан барагдуулах ажлыг зохион байгуулах талаар зөвлөж өгсөн байна. Үүний дагуу 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн АЗД-ын захирамжаар “Төлөөлөгч томилох тухай”, 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 01/2070 тоот албан бичгээр “итгэмжлэл олгох тухай” Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлалд хандсан ч тодорхой үр дүн гараагүй байна.

Аймгийн хөгжлийн сангийн журмын 4.4.8 дахь заалтын дагуу “Аймгийн хөгжлийн сан”-аас олгогдсон зээлээр хэрэгжиж буй ажил, төсөл нь төсөвт заагдсан норм, стандарт, хугацаанд хийгдэж байгаа эсэх, мөн хөрөнгийн эргэн төлөлтийн байдалд хяналт тавих үүргийг тухайн объект байрлаж буй сумын Засаг дарга хариуцан, ажлын хэсэг томилж, тогтмол хяналт тавих ёстой. Мөн хяналтын үр дүнг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст мэдээлж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах зохицуулалттай байна. Энэхүү заалтын хэрэгжилт хангалтгүй байгааг хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл нэмэгдэж буй байдал харуулж байна. Энэ нь сум, аймгийн түвшинд мэдээлэл солилцоо, хяналт, дүн шинжилгээ хийх, арга хэмжээ авах үйл ажиллагаа сул байгааг илтгэж байгаа бөгөөд журамд хариуцлагын тогтолцоог тодорхой заалт нэмж оруулах шаардлагатай байна.

Аймгийн хөгжлийн сангийн зээлийн гэрээний 3.2.6-д “Зээлдэгч зээлийг гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулаагүй болон зээл хүүгийн төлбөрийг төлөх хугацааг удаа дараа зөрчсөн тохиолдолд зээлийг эргүүлэн татах эрхтэй” гэж заасны дагуу зээлдэгчтэй хариуцлага тооцож ажиллаагүй байна.

Аймгийн Засаг даргын 2025 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн А/149 дугаар захирамж гарсантай холбогдуулан Аймгийн хөгжлийн сангаас авсан зээлийг зориулалтын дагуу зарцуулж байгаа, мөн гэрээний хуваарийн дагуу эргэн төлөлт хийж байгаа эсэх дээр хяналт тавьж иргэд, аж ахуйн нэгж, хоршоодтой тооцоо нийлэх ажлыг Батсүмбэр, Борнуур, Сүмбэр, Жаргалант, Баянчандмань, Баянцогт, Заамар, Цээл, Угтаал, Лүн, Баянхангай, Аргалант, Алтанбулаг сумдад 3 хоногийн хугацаанд зохион байгуулан ажилласан байна.

Гүйцэтгэлийн аудит хийх явцад Батсүмбэр, Борнуур, Сүмбэр, Жаргалант, Баянчандмань, Цээл, Угтаал, Эрдэнэ, Баяндэлгэр, Алтанбулаг, Сэргэлэн, Зуунмод сумдын төсөл хэрэгжүүлэгч буюу зээлдэгч бүртэй уулзаж төслийн зориулалтыг шалгаж, хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх мэдэгдэл өгч, заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд Монгол банкны мэдээллийн санд бүртгүүлэх талаар танилцуулж ажилласан.

Аудитын үр дүнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар АХС-аас олгосон зээлийн хэрэгжилтийг газар дээр нь очиж үзэн эргэн төлөлт хийгдээгүй, төлөх хугацаа хэтэрсэн зээлдэгч нартай уулзан зээлийн эргэн төлөлт 1,005.0 сая төгрөг төвлөрүүлж, бодитой үр дүнг бий болголоо.

Аудитаар нийт 4,973.9 сая төгрөгийн зөрчилд 133.0 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 721.1 сая төгрөгийн 3 албан шаардлага, 283.1 сая төгрөгийн 3 зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлэх, 3,836.7 сая төгрөгийн 7 зөвлөмж өгөгдлөө.

Дүгнэлт:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. АХС-ийн зээлийн эргэлтийн зохистой харьцаа алдагдаж, нийт авлагын 60.2 хувь нь хугацаа хэтэрч, чанаргүй зээлийн хэмжээ 6 дахин өссөн бөгөөд АХС-ийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаа үр дүнгүй байна.
2. АХС-ийн журам нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай тухай хуулиудтай уялдаа муутай, зарим заалт нь давхардсан, зөрчилтэй байдлаар тусгагдсан нь эрх зүйн зохицуулалтын тодорхойгүй байдал үүсгэж байна.
3. АХС-ийн Зөвлөл болон СТСХ-ээс сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, ашиглалтын байдал, үр дүнд тавих хяналтыг хэрэгжүүлээгүйгээс эрсдэлийн үнэлгээ сул, зээлийн эргэн төлөлт хангалтгүй, санхүүгийн сахилга бат, хариуцлагын тогтолцоо алдагдсан байна.
4. АХС-ийн журамд тусгагдаагүй “Итгэлийн зээл”, “Зээлжих батламж” нэрээр төсөл хөтөлбөрийг санхүүжүүлсэн, сангийн хөрөнгийг зарцуулах эрхгүй тухайн үеийн ХХААГ-ын дарга зээлийн гэрээг байгуулсан, шууд худалдан авалт хийсэн зэрэг нь сангийн зориулалт үйл ажиллагааг алдагдуулж хугацаа хэтэрсэн, чанаргүй зээл өсөх шалтгаан болсон байна.
5. АХС-ийн хөрөнгөөр аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулах төсөл, хөтөлбөрийг сонгон шалгаруулсан ч сангийн журам зөрчигдсөн, төслийн сонгон шалгаруулалтын ил тод байдал хангагдаагүй, мөн сум, орон нутгийн удирдлагууд төслийн талаар хангалттай мэдээлэлгүй байгаагаас шалтгаалан зарим төслүүд хэрэгжээгүй, зориулалт бусаар зарцуулагдсан байна.
6. Аймгийн хөгжлийн сангийн хөрөнгийн бүрдүлэлт, зарцуулалтад хяналт хийсэн шалгалтын үр дүнгээр Төрийн аудитын газар болон Санхүү хяналт дотоод аудитын газруудаас өгсөн албан шаардлага, зөвлөмжийг тухай бүр хэрэгжүүлж ажиллаагүйгээс алдаа, зөрчил давтан гарч даамжирсаар байна.
7. АХС-ийн харилцах данс нь арилжааны банкинд байршиж байгаа нь сангийн зарцуулалт, гүйлгээний ил тод байдал хангагдахгүй байх, ТБОНӨХБАҮХАТХ-д заасан худалдан авалтын зарчим зөрчигдөх, татварын тайлан бүртгэлд орлогыг дутуу тайлагнаснаас холбогдох хууль тогтоомж зөрчигдөх нөхцөл байдал үүсэж байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Засаг даргад :

1. Аймгийн хөгжлийн сангийн журмыг бусад ижил төрлийн сангуудын үйл ажиллагаа, зориулалттай давхардуулахгүйгээр холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлуулах,
2. Аудитад хамрагдсан хугацаанаас харахад хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл жилд 7.9 сая төгрөгөөс 1,227.4 сая төгрөг хүртэл өсч нийт 3,736.3 сая төгрөгийн эх үүсвэр дахин эргэлтэд ороогүй байгаа тул сангийн хөрөнгийн үр ашигтай байдал, санхүүгийн сахилга бат, хяналтын тогтолцоонд анхаарах шаардлагатай бөгөөд зээлийн эргэн төлөлтийн төлөвлөлт, хяналтыг сайжруулах, хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлэх
3. Сонгон шалгаруулсан төслүүдийн талаар сум, орон нутгийн удирдлагаас зээл зориулалтаар ашиглаж буй эсэхэд журамд заасан хяналтыг хэрэгжүүлж зээлийн эргэн төлөлтөд анхаарал хандуулж тухай бүрд мэдээлэл солилцож байх
4. Аймгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй төслүүдийн талаарх мэдээлэл түгээх, ил тод байдал, олон нийтэд хүргэх ажил хангалтгүй байгаа тул төсөл, арга хэмжээний үр дүнг ил тод тайлагнах, сум, багийн түвшинд мэдээлэл түгээх сувгуудыг сайжруулах
5. Хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулж зээлийн эх үүсвэр бүрдүүлж, аймгийн шилжих үлдэгдлээс мөнгө хувиарлан эх үүсвэр татахгүй байх

Засаг даргын Тамгын газрын СТСХ-ийн даргад :

1. Зээлийн эргэн төлөлтийг сайжруулах болон хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг зохих хэмжээнд хүртэл бууруулах, зориулалт бусаар зарцуулсан зээлийг хугацаанаас өмнө эргүүлэн татах, өмнөх аудитаар удаа дараа өгч байсан зөвлөмжийг хэрэгжүүлэх
2. Монгол банкны зээлийн мэдээллийн санд зээлдэгчийн мэдээллийг оруулах шаардлагыг хангасан программ ашиглан, хамтран зээлдэгчийн /хамаарал бүхий этгээдийг/ мэдээллийг хамт оруулан зээлийг төлүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах
3. Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн А122/А-172 дугаар хамтарсан тушаалын хавсралтын 2.9-д Банк нь төсвийн байгууллагын дансыг дараах үндэслэлээр хааж, тухайн дансны үлдэгдэл, түүнд тооцсон хүүгийн орлогын хамт төрийн сангийн холбогдох дансанд төвлөрүүлэх үүрэгтэй гэж заасныг мөн 2.9.5-д Үндэсний аудитын газраас тавьсан албан шаардлагыг үндэслэн арилжааны банкны үлдэгдлийг төрийн сангийн дансанд төвлөрүүлж, дансыг хаах
4. АХС-ийн Зөвлөл болон СТСХ-ээс сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, ашиглалтын байдал, үр дүнд тавих хяналтыг журамд заасны дагуу хэрэгжүүлэн тайланг Шилэн дансанд байршуулах

Тайлан хянасан:

Дарга, Тэргүүлэх аудитор
Аудитын менежер

Ц.Хишигжаргал
О.Амаржаргал

Тайлан бичсэн:

Ахлах аудитор
Аудитор
Аудитор

Ц.Саранчимэг
Д.Бямбасүрэн
Б.Нямсүрэн

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР

41111 Төв аймаг, Зуунмод сум, Номт 1 дүгээр баг
Утас: 70273623, И-мэйл: tuv_zdig@tov.gov.mn

2025. 07.25 № 05/1238

танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

“Аймгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт
зарцуулалт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын
тайлантай танилцсан болно.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Ю.БЯМБАЦОГТ

